


БАТЛАВ:

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
АЛБАНЫ ДАРГА**  **Н.ЖИГЖИДДОРЖ**

Огноо:2020.03.31

**УЛС, АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН, ЭХ ДЭЛХИЙДЭЭ ЭЭЛТЭЙ “ЭКО МАЛЧИН”
ШАЛГАРУУЛЖ ОЛГОХ ШАГНАЛЫН ЦОМ, ЭНГЭРИЙН ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХ
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр:

Улс, аймгийн аварга малчин, эх дэлхийдээ ээлтэй
“Эко малчин” шалгаруулж олгох шагналын цом,
энгэрийн тэмдэг, үнэмлэх бэлтгэн нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах ажил

Гэрээний дугаар:

09-ХА-13/2020

Захиалагч:
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Улиастай сум 2020 он

БАТЛАВ:

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
АЛБАНЫ ДАРГА**

Н.ЖИГЖИДДОРЖ

Огноо:2020.03.31

**УЛС, АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН, ЭХ ДЭЛХИЙДЭЭ ЭЭЛТЭЙ “ЭКО МАЛЧИН”
ШАЛГАРУУЛЖ ОЛГОХ ШАГНАЛЫН ЦОМ, ЭНГЭРИЙН ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХ
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр:

Улс, аймгийн аварга малчин, эх дэлхийдээ ээлтэй
“Эко малчин” шалгаруулж олгох шагналын цом,
энгэрийн тэмдэг, үнэмлэх бэлтгэн нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах ажил

Гэрээний дугаар:

09-ХА-13/2020

Захиалагч:

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Улиастай сум 2020 он

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Улс, аймгийн аварга малчин, эх дэлхийдээ ээлтэй “Эко малчин” шалгаруулж олгох шагналын цом, энгэрийн тэмдэг, үнэмлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажил</p> <p>Дугаар:09-ХА-13/2020</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь Санхүүгийн тайлангаа цахим систем, татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн санд 2018, 2019 онуудад татвар төлөлт, борлуулалтын орлого, ашгийн мэдээллийг оруулсныг шалгана. 2. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээг тендер зарласнаас хойшхи хугацаанд наториатаар баталгаажуулан ирүүлнэ. 3. Харьяа татварын алба болон нийгмийн даатгалын газраас өр, авлагын талаар тодорхойлолт авч тендерт хавсаргаж ирүүлнэ. Тодорхойлолтуудын хугацаа нь тендер зарласан өдрөөс хойш байна. Шаардлагатай гэж үзвэл захиалагч тендерт оролцогчийн татвар, НДШ төлөлтийн мэдээллийг холбогдох татвар, НД-ын байгууллагаас тендерийн нээлт хийсэн өдрөөр тодруулга авна. 4. Захиалагч татвар, НД-ын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. 5. Харилцагч банкнаас тодорхойлолт ирүүлнэ. 6. Харьяа шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг ирүүлнэ. 7. Захиалагч тендерт оролцогчийн Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, харилцах банкнаас тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй албан мэдэгдэл ирүүлнэ. 8. Борлуулалтын хэмжээ: [Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онууд] Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртөгийн 50%-иас багагүй байна. 9. Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: [Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онууд] Ядаж нэг удаа хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын төсөвт өртөг нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас багагүй байна. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт мөн захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.

	<p>10. Хуримтлагдсан ашиг алдагдал нь : Ашигтай ажилласан байх жилийн тоо: [Сүүлийн 2 жил 2017, 2018 онуудад]</p> <p>11. Техникийн тодорхойлолтонд дүйцэхүйц байна.</p> <p>12. Техникийн тодорхойлолтонд зааснаар тус бүр 1 хувь дээжийг ирүүлнэ.</p> <p>13. Аварга малчны цомыг тус бүрт нь хамгаалалттай хайрцаганд хийж ирүүлнэ гэж албан бичгээр баталгаажуулан ирүүлэх</p> <p>14. Бараа хүлээж авах эцсийн цэг: Завхан аймгийн Засаг даргын тамгын газар</p> <p>15. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд санал болгосон үнэд багтаан гэрээнд заасан үүргээ биелүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Дээрх нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажуулаагүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<p>ТӨЭЗ 2.1</p>	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд: Т.Сайннямбуу Байгууллагын хаяг: Завхан аймаг.Улиастай хот.Нутгийн удирдлагын ордон.Орон нутгийн өмчийн газар Давхар болон өрөөний дугаар: 4-р давхарт №417 тоот Аймаг, хот: Завхан аймаг.Улиастай хот Шуудангийн дугаар: байхгүй Улс: Монгол Улс Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2020 оны 04-р сарын 08-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
<p>ТӨЭЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Завхан аймгийн Нутгийн удирдлагын ордон.Орон нутгийн өмчийн газар Давхар болон өрөөний дугаар: 4-р давхар №417 Аймаг, хот: Завхан аймаг.Улиастай хот Шуудангийн дугаар: байхгүй Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 04-р сарын 08-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

“Аймгийн алдарт уяач” цомны тодорхойлолт

д/д	Үзүүлэлт	Тодорхойлолт
1	Цомны суурийн хэсэг	Цайвар ногоон чулуун хавтан дээр суулгана. Суурийн урт 16см, өргөн 10см –ээс доошгүй хэмжээтэй байна. Ногоон хавтанг суурийн хэсгээр 4 талаас нь гоёмсог хүрээгээр хүрээлнэ. Хүрээлэн суурь, Чулуун хавтангийн өндөр 6см –ээс доошгүй зузаантай, доод талаасаа хаалт хийж бэхэлсэн байна
2	Наалт	Чулуун хавтангийн зүүн урд өнцөгт Аймгийн алдарт уяач, баруун урд өнцөгт Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан 2020 гэсэн бичээс бүхий наалтыг байрлуулна.
3	Цом	Цайвар ногоон чулуун хавтан дээр эцэг мал болох адуун сүргийн манлай болох Азарга металл баримлыг байрлуулна. Эцэг малын баримал 12,5см-8,5см өндөртэй, урттай зөв харьцаатай байх ба алтан шармал байна.
4	Захиалах тоо	Цомыг 33 ширхгээр бэлтгэж, тохиролцсон хугацаанд хүлээлгэн өгөх ба тээвэрлэхэд гэмтэхээргүй бат бөх үзэмжтэй хайрцаг, сав баглаа боодолтой байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2

“Ай” Аймгийн Аврага тэмээчин” цомны тодорхойлолт

д/д	Үзүүлэлт	Тодорхойлолт
1	Цомны суурийн хэсэг	Цайвар ногоон чулуун хавтан дээр суулгана. Суурийн урт 18см, өргөн 10см –ээс доошгүй хэмжээтэй байна. Ногоон хавтанг суурийн хэсгээр 4 талаас нь гоёмсог хүрээгээр хүрээлнэ. Хүрээлэн суурь, Чулуун хавтангийн өндөр 6см –ээс доошгүй зузаантай, доод талаасаа хаалт хийж бэхэлсэн байна
2	Наалт	Чулуун хавтангийн зүүн урд өнцөгт Аймгийн аварга тэмээчин, Баруун урд өнцөгт Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан 2020 гэсэн бичээс бүхий наалтыг байрлуулна.
3	Цом	Цайвар ногоон чулуун хавтан дээр эцэг мал болох тэмээн сүргийн манлай болох буур металл баримлыг байрлуулна. Эцэг малын баримал 14,5см-10,5см өндөртэй, урттай зөв харьцаатай байх ба алтан шармал байна.
4	Захиалах тоо	Цомыг 3 ширхгээр бэлтгэж, тохиролцсон хугацаанд хүлээлгэн өгөх ба тээвэрлэхэд гэмтэхээргүй бат бөх үзэмжтэй хайрцаг, сав баглаа боодолтой байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

①

**“Аймгийн аварга малчин”-ны энгэрийн тэмдгийн
тодорхойлолт**

д/д	Үзүүлэлт	Тодорхойлолт
1	Үндсэн хэсэг	Аймгийн аварга малчны энгэрийн тэмдэг нь цацраг бүхий 5 хошуу хэлбэртэй, дээд талдаа зүүлтийн хэсэгтэй байна. 5 хошуу дотор дугариг давхар хүрээ хийж, цэнхэр өнгөөр суурь тавих ба хүрээний дээд хэсэгт Аймгийн аварга малчин гэсэн бичигтэй байна. Давхар хүрээний дотор Очирваань хайрханыг мөнх цасан мөнгөлөг дуулгатай, уулын энгэр хэсэг нь ногоон өнгөтэй, цэнхэр тэнгэртэй дүрсэлнэ. Уулын энгэрт 5 хошуу малын толгойг жижиг дугуй хүрээнд ялгарч танигдахуйц хэлбэрээр дүрсэлнэ.
2	Зүүлтийн хэсэг	Тэмдгийн зүүлтийн хэсэг нь шар хүрээтэй, цэнхэр дэвсгэртэй байх ба Завхан гэсэн үгийг гол хэсэгт нь товойлгон, шар өнгөөр бичсэн байна.
3	Зүүлт	Тэмдгийн зүүлт нь хувцасны энгэрт тогтооход хялбар, бат бэх, олон удаа зүүж, тайлахад эвдрэхээргүй хийгдсэн байна
4	Футляр, сав	Тэмдгийг тус бүрт нь зориулалтын уут, эсвэл футлярт /жижиг хайрцаг/ хийнэ.
5	Үнэмлэх	“Аймгийн аварга малчин” цол, тэмдгээр шагнасныг тодорхойлох аймгийн Засаг даргын гарын үсэг, дугаар, огноо бүхий үнэмлэхийг хавсралтад үзүүлсэн загварын дагуу хэвлэж бэлтгэн хүлээлгэн өгнө.
6	Тоо, ширхэг	Энгэрийн тэмдэг 100 ш, үнэмлэх 100 ш байна.

- Төсөв өртөг 33.000.000 төгрөг
- Эх үүсвэр-Орон нутгийн төсөв

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

④

"Аймгийн аварга малчин" цомын тодорхойлолт

Д/Д	Үзүүлэлт	Тодорхойлолт
1	Цомын суурийн хэсэг	Цайвар ногоон чулуун хавтан дээр суурилна. Суурийн урт 30 см, өргөн 17 см-ээс доошгүй хэмжээтэй байна. Ногоон хавтанг суурийн хэсгээр 4 талаас нь гоёмсог хүрээгээр хүрээлнэ. Хүрээлсэн суурь, чулуун хавтангийн өндөр 6 см-ээс доошгүй зузаантай, доод талаасаа хаалт хийж, бэхэлсэн байна.
2	Наалт	Чулуун хавтангийн зүүн урд өнцөгт Аймгийн аварга малчин өрх, баруун урд өнцөгт Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан 2020 гэсэн бичээс бүхий наалтыг байрлуулна.
3	Цом	Цайвар ногоон чулуун хавтан дээр 5 хошуу эцэг малын металл баримлыг эгнүүлэн байрлуулна. Эцэг малын баримлууд 4.5-6.5 см өндөртэй, 5.5-8.5 см урттай зөв харьцаатай байх ба алтан шармал өнгөтэй байна.
4	Очирваань хайрхан	Таван хошуу малын ар талаар Очирваань хайрханы дүрслэл байна. Хайрхан уул 13.5 см-ээс доошгүй өндөртэй, алтан шармал өнгөтэй, уулын оройн хэсэг мөнх цастай, мөнгөлөг өнгөтэй дүрслэгдсэн байна.
5	Захиалах тоо	Цомыг 50 ширхгийг бэлтгэж, тохиролцсон хугацаанд хүлээлгэн өгөх ба тээвэрлэхэд гэмтэхээргүй бат бөх үзэмжтэй хайрцаг, сав баглаа боодолтой байна

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

3

1. Бараа хүргэх газар: [Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар]

2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1							

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]